



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/32/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнгөншагай Утас: 90909190 Цахим хаяг: Mungunshagai.J@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. Агуулга

1.Аудитын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БГ	Боловсролын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
З.МӨНХТОГТОХ ТАНАА

2022.02.25 № 135  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,441,698.00</b>	<b>22,857,856.00</b>
2	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>16,441,698.00</b>	<b>22,857,856.00</b>
3	Хангамжийн материал	16,441,698.00	22,857,856.00
4	Аж ахуйн материал	16,441,698.00	22,857,856.00
5	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>131,492,643.18</b>	<b>144,170,923.97</b>
6	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>131,492,643.18</b>	<b>144,170,923.97</b>
7	<b>Биет хөрөнгө</b>	<b>131,492,643.18</b>	<b>144,170,923.97</b>
8	Барилга, байгууламж, орон сууц	15,000,000.00	15,000,000.00
9	Хуримтлагдсан элэгдэл	-2,781,250.00	-3,156,250.13
10	Авто-тээврийн хэрэгсэл	60,600,000.00	60,600,000.00
11	Хуримтлагдсан элэгдэл	-9,291,666.95	-15,351,666.95
12	Машин тоног төхөөрөмж(компьютер)	141,022,105.75	179,713,805.75
13	Хуримтлагдсан элэгдэл	-94,648,728.65	-110,120,826.13
14	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,054,750.29	50,054,750.29
15	Хуримтлагдсан элэгдэл	-30,810,071.26	-34,916,392.86
16	Ном	2,347,504.00	2,347,504.00
17	Програм хангамж	750,000.00	750,000.00
18	Хуримтлагдсан элэгдэл	-750,000.00	-750,000.00
19	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>147,934,341.18</b>	<b>167,028,779.97</b>
20	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>147,934,341.18</b>	<b>167,028,779.97</b>
21	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>147,934,341.18</b>	<b>167,028,779.97</b>
22	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	217,539,943.50	217,539,943.50
23	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-72,437,345.34</b>	<b>-53,342,906.55</b>
24	Өмнөх үеийн үр дүн	-72,437,345.34	-72,437,345.34
25	Тайлант үеийн үр дүн		19,094,438.79
26	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,831,743.02	2,831,743.02
27	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>147,934,341.18</b>	<b>167,028,779.97</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,258,795,397.21</b>	<b>2,640,699,913.18</b>
2	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>145,702,947.21</b>	<b>102,237,444.18</b>
3	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>145,702,947.21</b>	<b>102,237,444.18</b>
4	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>58,873,920.00</b>	<b>60,900,842.60</b>
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,040,000.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,873,920.00	58,860,842.60
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		15,855,000.00
8	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	86,829,027.21	25,481,601.58
9	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,113,092,450.00</b>	<b>2,538,462,469.00</b>
10	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,992,787,200.00</b>	<b>2,316,956,300.00</b>
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,992,787,200.00	2,316,956,300.00

12	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>120,305,250.00</b>	<b>200,372,569.00</b>
13	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
14	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,918,430.00	199,372,569.00
15	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,386,820.00	
16	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		<b>1,166,400.00</b>
17	Хаагдсан данс		1,166,400.00
18	<b>Төсвийн захирагчдаас</b>		<b>19,967,200.00</b>
19	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт		19,967,200.00
20	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,224,669,508.18</b>	<b>2,621,605,474.39</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,224,669,508.18</b>	<b>2,621,605,474.39</b>
22	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>560,819,975.02</b>	<b>620,794,286.60</b>
23	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>237,855,080.72</b>	<b>243,163,649.42</b>
24	Үндсэн цалин	196,148,411.77	219,849,533.93
25	Нэмэгдэл	37,124,800.00	19,183,245.49
26	Унаа хоолны хөнгөлөлт	2,742,445.95	1,357,502.00
27	Урамшуулал	1,839,423.00	2,773,368.00
28	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,088,700.00</b>	<b>28,170,259.60</b>
29	Тэтгэврийн даатгал	21,173,500.00	19,795,325.19
30	Тэтгэмжийн даатгал	2,228,800.00	2,134,096.94
31	ҮОМШӨ-ний даатгал	1,783,000.00	1,687,017.48
32	Ажилгүйдлийн даатгал	445,800.00	414,120.03
33	Эрүүл мэндийн даатгал	4,457,600.00	4,139,699.96
34	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,777,592.00</b>	<b>24,340,021.90</b>
35	Гэрэл, цахилгаан	3,123,217.00	2,785,151.00
36	Түлш, халаалт	19,257,385.00	19,136,584.00
37	Цэвэр, бохир ус	1,396,990.00	2,418,286.90
38	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>102,015,297.21</b>	<b>91,570,772.60</b>
39	Бичиг хэрэг	1,107,673.00	6,855,670.00
40	Тээвэр, шатахуун	5,471,820.00	4,084,632.00
41	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,054,427.00	1,012,628.00
42	Ном, хэвлэл	180,800.00	17,900.00
43	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	378,100.00	19,609,700.00
44	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,993,450.00	1,129,400.00
45	Бараа материал шилжүүлсний зардал	86,829,027.21	58,860,842.60
46	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>527,681.00</b>	<b>2,155,250.00</b>
47	Урсгал засвар	527,681.00	2,155,250.00
48	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,222,000.00</b>	<b>2,505,000.00</b>
49	Дотоод албан томилолт	2,222,000.00	2,505,000.00
50	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48,341,275.00</b>	<b>20,142,747.00</b>
51	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,913,344.00	20,142,747.00
52	Даатгалын үйлчилгээ	348,300.00	
53	Тээврийн хэрэгслийн татвар	79,631.00	
54	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>115,992,349.09</b>	<b>208,746,586.08</b>
55	Бараа үйлчилгээний бусад зардал	1,323,000.00	20,541,053.58

56	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	102,521,624.00	162,192,113.29
57	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,147,725.09	26,013,419.21
58	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,663,849,533.16</b>	<b>2,000,811,187.79</b>
59	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,637,398,200.00</b>	<b>1,936,393,500.00</b>
60	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,300,840,600.00	1,007,661,300.00
61	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,336,068,000.00	928,342,200.00
62	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	489,600.00	390,000.00
63	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>26,451,333.16</b>	<b>64,417,687.79</b>
64	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,451,333.16	62,152,025.71
65	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		2,265,662.08
66	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>34,125,889.03</b>	<b>19,094,438.79</b>
67	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>275,845.84</b>	
68	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	275,845.84	
69	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>33,850,043.19</b>	<b>19,094,438.79</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	217,539,943.50	2,831,743.02	-72,437,345.34	147,934,341.18
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	217,539,943.50	2,831,743.02	-72,437,345.34	147,934,341.18
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	19,094,438.79	19,094,438.79
4	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	217,539,943.50	2,831,743.02	-53,342,906.55	167,028,779.97

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,114,092,450.00</b>	<b>2,540,502,469.00</b>
2	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
3	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	0.00
4	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,113,092,450.00</b>	<b>2,540,502,469.00</b>
5	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,992,787,200.00</b>	<b>2,316,956,300.00</b>
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,992,787,200.00	2,316,956,300.00
7	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>120,305,250.00</b>	<b>223,546,169.00</b>
8	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,166,400.00
9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,918,430.00	220,339,769.00
10	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,386,820.00	2,040,000.00
11	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,114,092,450.00</b>	<b>2,517,665,769.00</b>

12	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,114,092,450.00</b>	<b>2,517,665,769.00</b>
13	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>450,242,916.84</b>	<b>516,854,581.21</b>
14	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>237,587,674.84</b>	<b>243,163,649.42</b>
15	Үндсэн цалин	195,881,005.89	219,849,533.93
16	Нэмэгдэл	37,124,800.00	19,183,245.49
17	Унаа хоолны хөнгөлөлт	2,742,445.95	1,357,502.00
18	Урамшуулал	1,839,423.00	2,773,368.00
19	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,088,700.00</b>	<b>28,170,259.60</b>
20	Тэтгэврийн даатгал	21,173,500.00	19,795,325.19
21	Тэтгэмжийн даатгал	2,228,800.00	2,134,096.94
22	ҮОМШӨ-ний даатгал	1,783,000.00	1,687,017.48
23	Ажилгүйдлийн даатгал	445,800.00	414,120.03
24	Эрүүл мэндийн даатгал	4,457,600.00	4,139,699.96
25	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,777,592.00</b>	<b>24,340,021.90</b>
26	Гэрэл, цахилгаан	3,123,217.00	2,785,151.00
27	Түлш, халаалт	19,257,385.00	19,136,584.00
28	Цэвэр, бохир ус	1,396,990.00	2,418,286.90
29	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,683,670.00</b>	<b>27,605,410.00</b>
30	Бичиг хэрэг	1,091,700.00	889,550.00
31	Тээвэр, шатахуун	2,969,220.00	4,084,632.00
32	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,024,300.00	1,012,628.00
33	Ном, хэвлэл	226,900.00	1,807,900.00
34	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	378,100.00	19,810,700.00
35	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,993,450.00	0.00
36	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>527,700.00</b>	<b>1,033,000.00</b>
37	Урсгал засвар	527,700.00	1,033,000.00
38	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,222,000.00</b>	<b>2,505,000.00</b>
40	Дотоод албан томилолт	2,222,000.00	2,505,000.00
41	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48,341,275.00</b>	<b>21,346,175.00</b>
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,913,344.00	21,346,175.00
43	Даатгалын үйлчилгээ	348,300.00	0.00
44	Тээврийн хэрэгслийн татвар	79,631.00	0.00
45	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>95,014,305.00</b>	<b>168,691,065.29</b>
46	Бараа үйлчилгээний бусад зардал	1,323,000.00	279,212.00
47	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,691,305.00	168,411,853.29
48	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,663,849,533.16</b>	<b>2,000,811,187.79</b>
49	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,637,398,200.00</b>	<b>1,936,393,500.00</b>
50	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,300,840,600.00	1,007,661,300.00
51	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,336,068,000.00	928,342,200.00
52	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	489,600.00	390,000.00
53	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>26,451,333.16</b>	<b>64,417,687.79</b>
54	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,451,333.16	62,152,025.71
55	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,265,662.08
56	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>0.00</b>	<b>22,836,700.00</b>

57	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>22,836,700.00</b>
58	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>22,836,700.00</b>
59	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>22,836,700.00</b>
60	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	22,836,700.00
61	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0.00</b>	<b>-22,836,700.00</b>
62	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
63	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>0.00</b>	<b>0.00</b>
64	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>0.00</b>	<b>0.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,316,956,300.00</b>	<b>2,253,796,537.92</b>	<b>63,159,762.08</b>	<b>97.3</b>
2	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,316,956,300.00</b>	<b>2,253,796,537.92</b>	<b>63,159,762.08</b>	<b>97.3</b>
3	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>319,668,700.00</b>	<b>317,403,037.92</b>	<b>2,265,662.08</b>	<b>99.3</b>
4	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>243,802,400.00</b>	<b>243,163,649.42</b>	<b>638,750.58</b>	<b>99.7</b>
5	Үндсэн цалин	202,758,300.00	219,849,533.93	-17,091,233.93	108.4
6	Нэмэгдэл	26,317,400.00	19,183,245.49	7,134,154.51	72.9
7	Унаа хоолны хөнгөлөлт	10,560,000.00	1,357,502.00	9,202,498.00	12.9
8	Урамшуулал	4,166,700.00	2,773,368.00	1,393,332.00	66.6
9	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,865,500.00</b>	<b>28,170,259.60</b>	<b>695,240.40</b>	<b>97.6</b>
10	Тэтгэврийн даатгал	20,496,900.00	19,795,325.19	701,574.81	96.6
11	Тэтгэмжийн даатгал	2,092,200.00	2,134,096.94	-41,896.94	102.0
12	ҮОМШӨ-ний даатгал	1,673,700.00	1,687,017.48	-13,317.48	100.8
13	Ажилгүйдлийн даатгал	418,400.00	414,120.03	4,279.97	99.0
14	Эрүүл мэндийн даатгал	4,184,300.00	4,139,699.96	44,600.04	98.9
15	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,894,500.00</b>	<b>24,340,021.90</b>	<b>554,478.10</b>	<b>97.8</b>
16	Гэрэл, цахилгаан	2,623,900.00	2,785,151.00	-161,251.00	106.1
17	Түлш, халаалт	19,505,800.00	19,136,584.00	369,216.00	98.1
18	Цэвэр, бохир ус	2,764,800.00	2,418,286.90	346,513.10	87.5
19	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,914,300.00</b>	<b>4,577,430.00</b>	<b>336,870.00</b>	<b>93.1</b>
20	Бичиг хэрэг	390,300.00	389,550.00	750.00	99.8
21	Тээвэр, шатахуун	2,965,800.00	2,962,352.00	3,448.00	99.9
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	827,600.00	1,012,628.00	-185,028.00	122.4
23	Ном, хэвлэл	196,600.00	77,900.00	118,700.00	39.6
24	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	148,500.00	135,000.00	13,500.00	90.9
25	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	385,500.00	0.00	385,500.00	0.0
26	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>484,000.00</b>	<b>479,000.00</b>	<b>5,000.00</b>	<b>99.0</b>
27	Дотоод албан томилолт	484,000.00	479,000.00	5,000.00	99.0

28	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,563,600.00</b>	<b>2,563,260.00</b>	<b>340.00</b>	<b>100.0</b>
29	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,563,600.00	2,563,260.00	340.00	100.0
30	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,144,400.00</b>	<b>14,109,417.00</b>	<b>34,983.00</b>	<b>99.8</b>
31	Бараа үйлчилгээний бусад зардал	298,400.00	279,212.00	19,188.00	93.6
32	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,846,000.00	13,830,205.00	15,795.00	99.9
33	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,997,287,600.00</b>	<b>1,936,393,500.00</b>	<b>60,894,100.00</b>	<b>97.0</b>
34	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,997,287,600.00</b>	<b>1,936,393,500.00</b>	<b>60,894,100.00</b>	<b>97.0</b>
35	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,068,058,400.00	1,007,661,300.00	60,397,100.00	94.3
36	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	928,837,500.00	928,342,200.00	495,300.00	99.9
37	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	391,700.00	390,000.00	1,700.00	99.6
38	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,316,956,300.00</b>	<b>2,253,796,537.92</b>	<b>63,159,762.08</b>	<b>97.3</b>
39	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,316,956,300.00</b>	<b>2,253,796,537.92</b>	<b>63,159,762.08</b>	<b>97.3</b>
40	Улсын төсвөөс санхүүжих	2,316,956,300.00	2,253,796,537.92	63,159,762.08	97.3
41	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
42	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
43	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>19</b>	<b>19</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
44	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
45	Гүйцэтгэх ажилтан	15	15	0.00	100.0
46	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.0
47	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>19</b>	<b>19</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
48	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14	14	0.00	100.0
49	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>222,288,243.29</b>
2	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>222,288,243.29</b>
3	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>222,288,243.29</b>
4	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,027,980.00</b>
5	Бичиг хэрэг	500,000.00
6	Тээвэр, шатахуун	1,122,280.00
7	Ном, хэвлэл	1,730,000.00
8	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,675,700.00
9	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,033,000.00</b>

10	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00
11	Урсгал засвар	1,033,000.00
12	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,026,000.00</b>
13	Дотоод албан томилолт	2,026,000.00
14	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,782,915.00</b>
15	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,782,915.00
16	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>158,418,348.29</b>
17	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	158,418,348.29
18	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>222,288,243.29</b>
19	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>222,288,243.29</b>
20	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
21	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	219,248,243.29
22	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,040,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Боловсролын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүллээ.

Архангай аймгийн Боловсролын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Боловсролын газар нь:

- “Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж монгол хэл сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ,
- Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна,

- Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ,
- Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно,
- Шинжлэх ухаан үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ гэсэн зорилтуудыг тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжтэй тул үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Боловсролын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 2,316.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 23.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 19.1 сая төгрөгөөр буюу 12.9 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Бараа материал	16.4	22.8	6.4	39.0
Үндсэн хөрөнгө	131.5	144.2	12.7	9.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>147.9</b>	<b>167.0</b>	<b>19.1</b>	12.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>147.9</b>	<b>167.0</b>	<b>19.1</b>	12.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>147.9</b>	<b>167.0</b>	<b>19.1</b>	12.9

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 39.0 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 16.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 15.9 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 25.4 сая төгрөг нийт 41.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 34.9 сая төгрөгийн зарцуулалт гарч, 22.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 9.6 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 131.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр худалдан авсан 22.8 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 15.8 сая төгрөг нийт 38.7 сая төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант хугацаанд байгуулсан 26.0 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 144.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 19.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,992.8	2,317.0	-675.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1.0	0.0	-1.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	120.3	223.5	103.2
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57.9	58.8	0.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	86.8	25.5	-61.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		15.9	15.9
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>3,258.8</b>	<b>2,640.7</b>	<b>-618.1</b>
Цалин, шимтгэлийн зардал	267.0	271.4	4.4
Бусад бараа үйлчилгээний зардал	293.9	349.4	55.5
Урсгал шилжүүлэг	2,663.8	2,000.8	-663.0
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>3,224.7</b>	<b>2,621.6</b>	<b>-603.1</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.3</b>		-0.3
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>33.8</b>	<b>19.1</b>	<b>-14.7</b>

Боловсролын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлого 103.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь корона вируст халдвар /ковид-19/ -ын цар тахалаас урьдчилан сэргийлэх үүднээс 2021-2022 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байр ариутгах зардал, Боловсролын чанарын шинэчлэл төсөл болон бусад зардалтай холбоотой байна. Мөн ковид-19 цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг сахих үүднээс олгосон материалтай тус тус холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 2,283.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 5.4 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 2,278.4 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 1.7 хувиар буюу 38.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ. Төсөв нэмэгдүүлсэн шалтгаан нь байр ашиглалттай зардал болон бусад зардалтай холбоотой нэмэгдсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,316.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 2,253.8 сая төгрөгийг зарцуулж, 63.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 2.7%-иар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Боловсролын газрын үндсэн цалин хүрэлцэхгүйн улмаас нэмэгдэл хөлс, унаа хоолны хөнгөлөлт, урамшууллын зардлаас 17.1 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна. Энэ талаар байгууллагын даргын 01/58 тоот албан бичгээр тайлбар ирүүлсэн болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дараах санхүүжилтүүд орж зарцуулагдсан байна. Үүнд:

- БСШУС-ын А/279 тушаал коронавируст халдвар /ковид-19/ -ын цар тахалаас урьдчилан сэргийлэх үүднээс 2021-2022 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байр ариутгах зардал 20.0 сая төгрөг
- МУЗГазар, Олон улсын хөгжлийн ассоциаци Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд сургуулиудад 146.3 сая төгрөг
- БШУС-ын 2021.11.22-ны өдрийн а/397 дугаар тушаалаар цахим контент сан бүрдүүлэх зорилгор контент боловсруулах лаборатори байгуулахад 19.0 сая төгрөг

- БСШУС-ын тушаалаар сурагчдын мэдлэг чадвар ялгаатай байдлыг оношлох үнэлгээ тогтоох шалгалтын материал боловсруулах бичиг хэргийн зардал болох 10.2 сая төгрөг
- Аймгийн Засаг даргын нөөц сангаас Монгол бичгийн өдөрт зориулан 1.1 сая төгрөгийг, Тогтвортой амьжиргаа II төслийн хүрээнд сумдын сургууль, цэцэрлэгүүдэд хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хяналтын зардалд 1.0 сая төгрөг
- Техникийн зөвлөн зохицуулах орон нутгийн багийн төслийн загвар сургуулиудад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд 6.0 сая төгрөгийг, байрны түрээсийн мөнгө 2.0 сая төгрөг
- Хүүхэд харах үйлчилгээний хөлсөнд БСШУЯ-с 17.9 сая төгрөг

Нэмэлт санхүүжилийн дансаар нийт 223.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч 222.2 сая төгрөгийг зарцуулан 1.3 сая төгрөгийн хэмнэлт гарган дээд шатны төсөв захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Архангай аймгийн Боловсролын газарт дараах онцлох асуудлууд гарсан байна. Үүнд:

1. Байгууллагын дарга Ц.Мөнхбатыг Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4-т заасны дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Б/09 дугаар захирамжаар ажлаас чөлөөлж, 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн Б/15 дугаар захирамжаар З.Мөнхтогтохыг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байна. Тухайн албан тушаалд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон өдрөөс хойш 8 сарын хугацаанд сонгон шалгаруулалт явуулаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.2 дахь заалттай нийцээгүй байна.
2. Тус байгууллагын дарга нь 2021.03.24-ний өдрийн б/08 тоот тушаалаар мэдээллийн ажилтан, зохицуулагч Ч.Мөнхбатыг, 2021.06.02-ны өдрийн б/10 тоот тушаалаар жолооч Г.Лхагвадорж нарыг тус тус ажлаас чөлөөлсөн байна. Ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтнууд Архангай аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж, иргэний хэргийн шүүхээс дараах шийдвэрүүд гарчээ. Үүнд:

- Ч.Мөнхбатын нэхэмжлэлд: Архангай аймгийн сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2021.07.05-ны өдрийн 129/ШШ2021/00331 дугаар бүхий тухайн албан тушаалд эгүүлэн томилох шийдвэр гарчээ. Уг шийдвэрийн дагуу 2021.09.01-ний өдөр үүрэгт ажилдаа эргэн томилогдсон байна. Ч.Мөнхбат нь ажилгүй байсан хугацаандаа Ихтамир сумын ЕБС-ийн менежерээр ажиллаж байсан тул Шүүхээс цалинг нөхөн олгох шийдвэр гараагүй байна.

- Г.Лхагвадоржийн нэхэмжлэлд: Архангай аймгийн сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2021.08.11-ний өдрийн 129/ШШ2021/003379 дугаар бүхий Г.Лхагвадоржийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 96.3 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 532.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Байгууллагын дарга нь албан ажлаас чөлөөлөгдсөн тул даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч шинээр томилогдон 12.3 сая төгрөгийн цалин олгосон нь зайлшгүй шаардлагатай албан тушаалын томилгоо хийсэн байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй тул судалгааг гаргаж ирүүлээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль /Local.audit.mn сайтад шивсэн/, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн хэрэгжилт, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Боловсролын газар нь 2021 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 135 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулсан бол 12 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийг хэрэгжүүлж, 2022 оны шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол, бүрэн мэдээлэх албан шаардлага хүргүүлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийн тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай

нийцүүлж үзэхэд байгууллагын зарцуулбал зохих нэн шаардлагтай зардлуудыг хасч тооцход 10 хувийн хэмнэлт 2.2 сая төгрөгийг бий болгосон байна.

Тайлант онд тус байгууллагын даргын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.2 дахь заалттай нийцээгүй байна. Иймд Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, тухайн албан тушаалд сонгон шалгаруулалт явуулах зөвлөмж хүргүүлжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.2 дахь заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтын дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 78.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 74.7 сая төгрөгийн алдааг залруулж, 3.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ.

Залруулагдаагүй 3.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдал 17.4 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### **4.1 Албан шаардлага**

Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас 3.8 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө худалдан авсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Төсвийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг дагаж мөрдөн ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

-----oOo-----

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Боловсролын газар	Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан 74.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд зөрүүтэй тусгасанг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлээ.	1	74.7	1	74.7						
2		Бараа үйлчилгээний бусад зардлаас 3.8 сая төгрөгийн өртөг хөрөнгө худалдан авсан зөрчил илэрлээ.	1	3.8					1	3.8		
3		Байгууллагын даргын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулаагүй	1									1
Дүн			3	78.5	1	74.7			1	3.8	1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Боловсролын газар	Шилэн дансны цахим хуудсанд 12 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан	1							1		
Дүн			1						1			
Нийт дүн			4	78.5	1	74.7			2	3.8	1	